



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/04

Зуунмод

Цагдаагийн бие бүрэлдэхүүнийг
өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар
зэрэглэлд шилжүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.6, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 56 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн бие бүрэлдэхүүнийн өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэглэлд шилжүүлж ажиллуулах тухай”, 2015 оны Б/99 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам” /код 136/-ын 136.4.2-ын “а”, “д” дэх заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. Арван долдугаар жарны “Муу нүүрт” хэмээх гал бичин жилийн сар шинийн баяр, амралтын өдрүүдэд иргэд, олон нийтийн амгалан тайван байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус Цагдаагийн газар, Заамар сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн алба хаагчдыг 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 09⁰⁰ цагаас 02 сарын 15-ны өдрийн 09⁰⁰ цаг хүртэлх хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэглэлд шилжүүлж ажиллуулсугай.

2. Баяр амралтын өдрүүдэд Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, Цагдаагийн газрын даргыг мэдээллээр хангах үүрэгтэй ажиллах Ерөнхий эргүүл, ёс журмын эргүүл, жижүүрийн шуурхай бүрэлдэхүүний хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах автомашинд шаардагдах шатах, тослох материалын зардлыг тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Н.Дашдаваа/-д зөвшөөрсүгэй.

4. Алба хаагчид гар утас станцуудыг байнгын бэлэн байдалд байлгаж, хаягаа Цагдаагийн газрын жижүүрт мэдэгдэж тэмдэглүүлэх ба Цагдаагийн хүрээнээс зохих зөвшөөрөлгүйгээр гарахыг хориглосугай.

5. Бие бүрэлдэхүүнд болон хөдөө сумдад ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч, цагдаа, зохицуулагч, цагдаа зохицуулагч нарт Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу тодорхой үүрэг өгөх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл бүрийг хүлээн авч, шийдвэрлэлтэд хяналт тавьж үр дүнг тооцох, Саатуулах байрны үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, хууль ёс, хүний эрх зөрчигдөхгүй байхад анхаарч ажиллахыг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа О.Батбаатар/, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга /цагдаагийн хошууч Ю.Чулуунбаатар/, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Т.Лхагвасүрэн/, Замын цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбаяр/, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга /цагдаагийн хошууч Н.Доржбалжид/, Төлөвлөлт, зохион байгуулалтын


45000018

тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Анхбаатар/, Заамар сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга /цагдаагийн дэд хурандаа Р.Ариунболд/ нарт тус тус үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг хэлтэс, тасгийн дарга нарт, биелэлтэд хяналт тавьж, дүнг нэгтгэн 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 09⁰⁰ цагт илтгэх хуудсаар танилцуулахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Т.Лхагвасүрэн /-д даалгасугай.

7. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



А.БАТБАЯР

Tushaal